



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/114/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

## **Агуулга**

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын ТАЙЛАН .....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	17
4.3 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/124  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020392

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,790,880.20</b>	<b>25,363,180.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>24,790,880.20</b>	<b>25,363,180.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>24,562,880.20</b>	<b>25,131,180.00</b>
35420	Аж ахуйн материал	23,597,355.20	23,524,750.00
35460	Хүнсний материал	965,525.00	1,606,430.00
35600	Мал амьтад	228,000.00	232,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>135,009,703.47</b>	<b>211,821,982.63</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>135,009,703.47</b>	<b>211,821,982.63</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>125,461,703.47</b>	<b>202,317,982.63</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	129,034,213.83	209,019,975.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(13,006,797.88)	(18,577,446.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21,401,060.80	24,205,845.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,402,994.55)	(16,263,121.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,781,981.27	16,655,532.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,430,378.70)	(14,444,422.01)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,607,688.30	3,096,188.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,523,069.60)	(1,374,569.60)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>9,548,000.00</b>	<b>9,504,000.00</b>
39301	Програм хангамж	1,023,060.00	1,177,060.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(825,060.00)	(1,023,060.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,350,000.00	9,350,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>159,800,583.67</b>	<b>237,185,162.63</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>159,800,583.67</b>	<b>237,185,162.63</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	159,800,583.67	237,185,162.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	37,410,383.91	37,410,383.91
51101	Өмч: - төрийн	37,410,383.91	37,410,383.91
512	Хуримтлагдсан үр дүн	(9,993,357.12)	67,391,221.84
51210	Өмнөх үеийн үр дүн	(9,993,357.12)	(9,993,357.12)
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	77,384,578.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	132,383,556.88	132,383,556.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>159,800,583.67</b>	<b>237,185,162.63</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>109,519,498.30</b>	<b>250,391,712.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>86,234,312.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	86,234,312.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	84,120,762.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	4,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө /	00.00	84,116,762.00
120006	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал /		2,113,550.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>26,200,798.30</b>	<b>22,784,900.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	83,318,700.00	141,372,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	15,213,898.30	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,802,200.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,411,698.30	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10,986,900.00	22,784,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,986,900.00	22,784,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>101,286,392.00</b>	<b>173,007,133.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>101,286,392.00</b>	<b>173,007,133.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	87,484,192.00	164,194,440.27
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	60,495,634.00	107,361,663.00
210101	Үндсэн цалин	41,895,815.00	76,947,267.91
210102	Нэмэгдэл	10,032,733.00	15,728,833.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,772,000.00	4,056,105.22
210104	Урамшуулал	5,795,086.00	10,629,456.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,844,064.42	14,002,849.23
210201	Тэтгэврийн даатгал	5,441,838.82	9,718,745.68
210202	Тэтгэмжийн даатгал	601,717.12	1,073,616.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	481,373.71	858,893.37
210204	Ажилгүйдлийн даатгал	115,700.53	204,359.30
210205	Эрүүл мэндийн даатгал	1,203,434.24	2,147,233.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,841,196.00	19,777,545.00
210301	Гэрэл, цахилгаан	2,919,026.00	1,316,045.00
210302	Түлш, халаалт	6,922,170.00	18,461,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	814,600.00	2,751,301.00
210401	Бичиг хэрэг	40,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	120,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,000.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	613,600.00	1,584,550.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	546,751.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,992,398.30	7,240,345.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,000.00	44,520.00

Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	2,926,398.30	7,095,825.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,044,000.00	100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	500,000.00
210604	Урсгал засвар	00.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.00	76,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	76,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	55,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,441,299.28	12,484,737.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	541,000.00	3,839,254.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	302,000.00	550,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,598,299.28	8,095,482.84
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13,802,200.00	8,812,692.77
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,802,200.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,802,200.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	8,812,692.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	8,812,692.77
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>8,233,106.30</b>	<b>77,384,578.96</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>8,233,106.30</b>	<b>77,384,578.96</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>37,410,383.91</b>	<b>132,427,896.72</b>	<b>(5,090,152.19)</b>	<b>164,748,128.44</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,410,383.91	132,427,896.72	-5,090,152.19	164,748,128.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	163,302.52	163,302.52
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>37,410,383.91</b>	<b>132,383,556.88</b>	<b>-9,993,357.12</b>	<b>159,800,583.67</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,410,383.91	132,383,556.88	-9,993,357.12	159,800,583.67
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	77,384,578.96	77,384,578.96
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>37,410,383.91</b>	<b>132,383,556.88</b>	<b>67,391,221.84</b>	<b>237,185,162.63</b>

Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>189,567,333.30</b>	<b>164,157,400.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>189,567,333.30</b>	<b>164,157,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	151,649,200.00	141,372,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>16,287,733.30</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,802,200.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,485,533.30	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>21,630,400.00</b>	<b>22,784,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,630,400.00	22,784,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>186,883,800.00</b>	<b>163,366,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>186,883,800.00</b>	<b>163,366,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>152,294,251.16</b>	<b>154,553,707.23</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>104,180,847.28</b>	<b>106,822,112.23</b>
210101	Үндсэн цалин	69,404,760.55	76,407,717.14
210102	Нэмэгдэл	23,126,012.29	15,728,833.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,592,000.00	4,056,105.22
210104	Урамшуулал	8,058,074.44	10,629,456.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,556,883.88</b>	<b>14,542,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	9,489,683.88	10,233,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,017,500.00	1,077,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	813,700.00	861,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	203,700.00	215,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,032,300.00	2,153,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,621,935.00</b>	<b>19,777,545.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,261,510.00	1,316,045.00
210302	Түлш, халаалт	17,305,425.00	18,461,500.00
210303	Цэвэр, бохир ус	55,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,499,200.00</b>	<b>2,210,000.00</b>
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,129,200.00	1,590,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,494,085.00</b>	<b>9,281,250.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	44,520.00
210502	Хоол, хүнс	10,949,085.00	7,736,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20,000.00</b>	<b>76,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	20,000.00	76,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>522,000.00</b>	<b>00.00</b>

Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	522,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,899,300.00</b>	<b>1,344,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,404,300.00	794,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	495,000.00	550,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,589,548.84</b>	<b>8,812,692.77</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,802,200.00</b>	<b>00.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,802,200.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>8,812,692.77</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	8,812,692.77
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,508,465.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,508,465.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>18,278,883.84</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,278,883.84	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,683,533.30</b>	<b>791,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>198,000.00</b>	<b>791,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>198,000.00</b>	<b>791,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>198,000.00</b>	<b>791,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	198,000.00	791,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(198,000.00)</b>	<b>(791,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>2,485,533.30</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>164,157,400.00</b>	<b>155,344,707.23</b>	<b>8,812,692.77</b>	<b>94.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>164,157,400.00</b>	<b>155,344,707.23</b>	<b>8,812,692.77</b>	<b>94.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>164,157,400.00</b>	<b>155,344,707.23</b>	<b>8,812,692.77</b>	<b>94.6</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>107,722,100.00</b>	<b>106,822,112.23</b>	<b>899,987.77</b>	<b>99.2</b>
210101	Үндсэн цалин	72,269,200.00	76,407,717.14	-4,138,517.14	105.7
210102	Нэмэгдэл	20,121,800.00	15,728,833.77	4,392,966.23	78.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,960,000.00	4,056,105.22	-96,105.22	102.4
210104	Урамшуулал	11,371,100.00	10,629,456.10	741,643.90	93.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>14,542,400.00</b>	<b>14,542,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,233,600.00	10,233,800.00	-200.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,077,300.00	1,077,400.00	-100.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	861,800.00	861,800.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	215,500.00	215,600.00	-100.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,154,200.00	2,153,800.00	400.00	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогмол зардал</b>	<b>22,284,900.00</b>	<b>19,777,545.00</b>	<b>2,507,355.00</b>	<b>88.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,623,400.00	1,316,045.00	2,307,355.00	36.3
210302	Түлш, халаалт	18,461,500.00	18,461,500.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	0	200,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,040,000.00</b>	<b>2,847,000.00</b>	<b>193,000.00</b>	<b>93.7</b>
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	200,000.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	50,000.00	37,000.00	13,000.00	74.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	120,000.00	180,000.00	40.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.00	2,190,000.00	0.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>14,468,000.00</b>	<b>9,281,250.00</b>	<b>5,186,750.00</b>	<b>64.2</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	44,520.00	480.00	98.9
210502	Хоол, хүнс	12,923,000.00	7,736,730.00	5,186,270.00	59.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>100,000.00</b>	<b>76,000.00</b>	<b>24,000.00</b>	<b>76.0</b>
210702	Дотоод албан томилолт	100,000.00	76,000.00	24,000.00	76.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	1,498,400.00	1,600.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	950,000.00	948,400.00	1,600.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	550,000.00	0.00	100.0

Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>164,157,400.00</b>	<b>155,344,707.23</b>	<b>8,812,692.77</b>	<b>94.6</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>141,372,500.00</b>	<b>133,461,395.00</b>	<b>7,911,105.00</b>	<b>94.4</b>
<b>310003</b>	<b>Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих</b>	141,372,500.00	133,461,395.00	7,911,105.00	94.4
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>22,784,900.00</b>	<b>21,883,312.23</b>	<b>901,587.77</b>	<b>96.0</b>
320001	Орон нутгийн төсвөөс	22,784,900.00	<b>21,883,312.23</b>	<b>901,587.77</b>	<b>96.0</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	0.00	-
610001	Төсвийн байгууллага	1	0	1	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	9	0	9	-
620001	Удирдах ажилтан	1	0	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	4	0	4	-
620003	Үйлчлэх ажилтан	4	0	4	-
620004	Гэрээт ажилтан	0	0	0	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, авлага, өглөгийн тооцоо нийлэх, хөрөнгийн дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг Ч.Мөнхтуяа хэрэгжүүлж, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтыг эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд Төв аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд 10 дугаар сарын 10-ны өдрөөс 13-ны өдрүүдэд хяналт шалгалт хийгдэж “ажиллагсдад цалингийн нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг алдаатай тооцсон” гэж төлбөрийн акт тогтоосон байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 594,570.6 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 5,945.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,161.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Баян сумын хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### ***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 164,157.4 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

#### ***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 4,131.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 79,985.7 мянган төгрөгийн барилга байгууламж, бусад хөрөнгө 791.0 мянган төгрөг нийт 84,907.7 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 791.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 84,116.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 2,117.5 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 12,691.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 14,234.63 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

#### ***Авлага, өглөгийн талаар:***

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй гарсан байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

#### ***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 25,363.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 211,822.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	24,790.9	25,363.2	572.3
Үндсэн хөрөнгө	135,009.7	211,822.0	76,821.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>159,800.6</b>	<b>237,185.2</b>	<b>77,384.6</b>
Засгийн газрын хувь оролцоо	159,800.6	237,185.2	77,384.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>159,800.6</b>	<b>237,185.2</b>	<b>77,384.6</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө данс тайлант онд 79,985.8 мянган төгрөгийн барилгын засвар хийгдэж сайжруулалт хийгдсэнээс шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 150,551.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22,784.9 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 173,336.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 9,178.6 мянган төгрөгөөр бууруулан 164,157.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 22,784.9 мянга, улсын төсвөөс 141,372.5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 141,372.5 мянган, орон нутгийн төсвөөс 22,784.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 155,344.7 мянган төгрөгийг зарцуулж, 8,812.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 155,344.7 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,507.4 мянга, хоол хүнсний зардлыг 5,186.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд цэцэрлэгийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 94.6 хувийн биелэлттэй, буюу төсвийг хэмнэлтэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Төсвийг бүлэг дотор зардлын хэтрэлт үүсгэж цалин хөлсийг 4,393.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар нийт 5,805.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 5,805.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна

#### **3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

Байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 25,386.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

##### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 25,386.6 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-н тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

###### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад эд хариуцагчийг карт, тооцоо бодсон баримт, тооллогын комиссын илтгэх хуудас, өмч хамгаалах зөвлөлийн тэмдэглэл, байгууллагын удирдлагад танилцуулсан тэмдэглэл, тооллогын баталгаа хийгдээгүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д. “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 72.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй үнэлгээ ба хуваарилалт, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

##### **2. Шилэн данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 113,401.4 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5,519.5 мянган төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

###### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэг	3	25,386.6							3	25,386.6
	ДҮН	3	25,386.6							3	25,386.6